



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 850,709,100.44 (найман зуун тавин сая долоон зуун есөн мянга нэг зуун төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 11 /арван нэгэн/ ширхэг тээврийн хэрэгслийг ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Хилийн 0286 дугаар ангийн захирагч, дэд хурандаа М.Эрдэнэбүрэн, "Боловсролын мэдээллийн технологийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тодгэрэл, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Хархорин АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах, "Ховд-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б. Батсүх, "Орхон АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Батзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хасаж шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001319

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 12 өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	2	3	4	5	6	7
1	Ниссан Патрол, суудлын 06-31 ОРХ, суудлын, арал-JN1TFSY61Z0559474	2011	100,000,000.00	Хилийн 0286 дугаар анги	15,000,000.00	1
2	Киа бонго, ачааны III 4WD, 68-66 ОРО арал-KNCSHY71CC7638664	2012	35,968,554.00		2,000,000.00	1
3	Трактор "Камацу" WB93R №04	2004	143,892,643.44		18,000,000.00	2
4	УАЗ-22069 фургон 43-15 ОРО	2011	23,000,000.00	Хил хамгаалах ерөнхий газар	1,000,000.00	1
5	Кран - балка 5 тн,пролёт 9м	2012	35,137,094.00		3,000,000.00	1
6	Ниссан патрол SGL 99-39 ОРА арал-JNITCSY61ZO562356	2006	54,254,040.00		3,000,000.00	1
7	Тоёота ландкрузейр-70, суудлын. 2866 ОРО, арал-JTGEB73J3B9005997	2011	88,678,695.00	"Боловсролын мэдээллийн технологийн төв" ТӨҮГ	14,000,000.00	2
8	Хьюндай Старикс, суудлын 39-84 оро арал KMAVA37HABU317791	2011	42,964,575.00	"Ховд АЗЗА" ТӨХК	3,000,000.00	1
9	Трубоукладчик ТР 12,19,02 наб №623	2007	202,166,250.00		2,500,000.00	1
10	Тоёота ландкрузейр-100, суудлын, 5665 ОРО, арал-JTEHJOGJ225053053	2011	88,678,695.00	"Хархорин АЗЗА" ТӨХК	14,000,000.00	1
11	Киа бонго, ачааны III 4WD, 87-52 ОРО, арал-KNCSHY76CK691729	2012	35,968,554.00	"Орхон АЗЗА" ТӨХК	1,500,000.00	1
Нийт дүн			850,709,100.44		77,000,000.00	
			(найман зуун тавин сая долоон зуун есөн мянга нэг зуун төгрөг дөчин дөрвөн мөнгө)	(далан долоон сая)		